

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН  
ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ, АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН  
ЗАХИРАМЖ, ТУШААЛ

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар А/18 -А/09

Улаанбаатар  
хот

Хамтарсан ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.3.д, 29.1.3.н, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.3, Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛЖ/ ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, нийслэлийн хүн ам өсөлт, хотжилт тэлж иргэд олноор оршин сууж, амьдрах болсны улмаас Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/18 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаарлалт"-ыг шинэчлэн тогтоосон бөгөөд суурьшлын бүсэд байгаа "Найрамдал" шар шаврын орд бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны улмаас иргэдийн эрүүл, аюулгүй байдал, тав тухтай амьдрах орчинд сөргөөр нөлөөлж буй эсэхийг холбогдох хуулиуд болон тогтоол шийдвэр, захирамжийн хүрээнд судалгаа хийн, шаардлагатай тохиолдолд суурьшлын бүсээс гаргах асуудлыг судлах, авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Батбаясгалан	-Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	М.Энхжаргал	-Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн асуудал хариуцсан орлогч дарга;
	Н.Батбаяр	-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга; /тохиролцсоноор/
	Э.Анар	-Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга;

А. Даваажаргал	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Л. Эрдэнэчулуун	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
Э. Болорчулуун	Нийслэлийн Газрын албаны дарга
Э. Баттулга	Нийслэлийн Байгаль орчны газрын дарга
Д. Мөнх-Учрал	Нийслэлийн Татварын газрын дарга
Ж. Сандагсүрэн	Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга
Ж. Батмагнай	Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль, эрх зүйн газрын дарга
Б. Бямбадагва	Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д. Эрдэнэтунгалаг	Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн мэргэжилтэн
Г. Алтанхуяг	Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтсийн мэргэжилтэн
Т. Оюунтунгалаг	Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б. Болортуяа	Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга
Д. Батмагнай	Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн хийж гүйцэтгэх ажлын удирдамжийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд тус тус танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд тавих хяналтыг өөртөө үлдээсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН  
ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ  
П.БАЯРХҮҮ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.ХЭРЛЭН

Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын хамтарсан 2018 оны 01 сарын 10-ны өдрийн А/18 захирамж, тушаалын 1 дүгээр хавсралт

## ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" болон Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/18 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаарлалт"-ыг тогтоосон.

Ашигт малтмалын газраас Сонгинохайрхан дүүргийн Найрамдал шар шаврын ордод 1997-2002 онуудад түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 6 аж ахуйн нэгж байгууллагын 7 талбайд, нийт 174,87 га газрыг хамруулан олгосон. Уг ордыг анх 1945 онд нээж илрүүлж, 1962 оноос эхлэн Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, барилгажуулалтад шаардлагатай тоосгоны шаврыг олборлох, үйлдвэрлэх үндсэн орд болгон ашиглаж ирсэн. Хүн ам өсөлт, хотжилт тэлэхийн хирээр дээрх газар орчимд иргэд олноор оршин сууж, амьдарснаар суурьшлын бүс болгон төлөвлөж өөрчлөхөд хүрсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон холбогдох тогтоол шийдвэр, захирамжийн дагуу Найрамдал шар шаврын ордыг эзэмшигч аж ахуй нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд судалгаа хийн, суурьшлын бүсээс гаргахтай холбогдсон асуудлыг судлах, шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах ажлыг зохион байгуулна.

### Хоёр. Бүрэлдэхүүн, хугацаа

Ажлын хэсэг нь хамтарсан захирамж, тушаалаар байгуулагдсан бүрэлдэхүүнтэйгээр 2018 оны 01 дүгээр сарын сарын 03-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулна.

### Гурав. Хамрах хүрээ

Сонгинохайрхан дүүргийн "Найрамдал" шар шаврын ордод түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монгол керамик" ХХК, "Сүмбэр хунтан" ХХК, "ЦДЦ" ХХК, "Солонгобил" ХХК, "Шинэ тоосго" ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй 174,87 га талбай хамаарна.

### Дөрөв. Хийгдэх ажлууд

Сонгинохайрхан дүүргийн 27.000 иргэд оршин суугчдын эрүүл, аюулгүй байдал, тав тухтай амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, суурьшлын бүс болох Баянхошууны гэр хорооллын айл өрхтэй зэрэгцэн оршиж буй "Найрамдал" шар шаврын ордоос шавар олборлох үйл ажиллагаа нь нийт иргэдийн эрх ашгийг хөндсөөр байна. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хүрээлэн буй орчны тэнцвэрийг хадгалах, агаар, орчны бохирдол,

тоосжилтоос сэргийлэхийн тулд тус ордод тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бүр мөсөн зогсоох, тусгай зөвшөөрлийг цуцлах эсхүл суурьшлын бүсийн гадна талбай болон алслагдсан орон нутагт дүйцүүлэх хэлбэрээр ашиглалтын талбай зааж өгөх, аж ахуйн нэгж тус бүрийн саналыг сонсох, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, асуудлыг судлан, цаашид шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттай авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш уулын ажлын тайлан, төлөвлөгөө батлуулж ажилласан байдал;

- Ашиглалт, олборлолтын хэмжээ, нийт ашигласан талбайн хэмжээ;
- Ашиглалт, олборлолт явуулаагүй талбайн хэмжээ;
- Байгалийн нөөц ашигласны төлбөр төлсөн байдал;
- Нөөцийн үлдэгдлийн хэмжээ;
- Олборлолтод өртсөн талбайн байгаль орчинд учруулсан экологи, эдийн засгийн үнэлгээ;

- Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ;
- Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулсан мэдээлэл, нийт дүн;

- Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрийг буцаан авсан мэдээлэл, нийт дүн;
- Нөхөн сэргээлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ;
- Нөхөн сэргээлт хийсэн талбайг актаар хүлээлгэн өгсөн мэдээлэл;
- Уул уурхайн ашиглалт явуулахад бичиг баримтын бүрдэл ханган ажилласан байдал;

- Аж ахуйн нэгж байгууллагын татвар төлөлтийн байдал;
- Харьяатай дүүрэгтэй хамтран ажилласан байдал, ус ашиглах, газар ашиглах, нийгмийн хариуцлагын гэрээ зэргийг хийж, дүгнүүлсэн байдал;
- Аж ахуйн нэгж байгууллагын саналыг сонсох, уулзалт зохион байгуулах;
- Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй нөхцөл байдал;
- Тоосгоны үйлдвэрлэлийн талбайн хог хаягдал, цацрагийн судалгаа, шинжилгээ;
- Хууль, дүрэм, журамд нийцсэн байдал;
- Бусад шаардлагатай.

Тав. Арга хэмжээний санал танилцуулах

Ажлын хэсгээс цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн гаргаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд тус тус танилцуулна.